



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монсам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан нийт 11 нэрийн 945,461,680.08 (есөн зуун дөчин таван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга зургаан зуун наян төгрөг найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 388,688,048.6 (гурван зуун наян найман сая зургаан зуун наян найман мянга дөчин найман төгрөг жаран мөнгө) төгрөгийн дахин үнэлсэн үнэ (2015 оны) бүхий хөрөнгийг багцлан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Монсам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Татан буулгах комиссын дарга В.Дарханбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогоос зохих захиргааны актын дагуу өр төлбөрийг барагдуулж үлдсэнийг улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. “Монсам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хаалтын тайлан тэнцлийг бэлтгэн батлуулах.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000237

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дүгээр сарын 27-ны өдрийн
105 дугаар тогтоолын хавсралт

**"МОНСАМ" ХХК-ийн ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ, ХУДАЛДАХ ДООД ҮНЭ**

Д/д	Хөрөнгийн нэр, дугаар	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дахин үнэлсэн үнэ /2015 он/	Балансын үнэ (төгрөг- 2019.12.31)	Хуримтлагдсан элэгдэл үнэ (тооцсон- 2019.12.31)	Үлдэгдэл өртөг (төгрөг- 2019.12.31)	Дуудлагын худалдааны доод үнэ (төгрөг)
1	Ариутгагч	1995	ш	1	19,035,200.00	95,176,000.00	95,176,000.00	0.0	150,000,000.00
2	Тариур савлах машин 5	1995	ш	1	12,831,130.00	64,155,650.00	64,155,650.00	0.0	
3	Нэр бичих машин	1995	ш	2	5,640,060.00	56,400,600.00	56,400,600.00	0.0	
4	Тариур угсрах шугам	1995	ш	2	17,343,200.00	173,432,000.00	173,432,000.00	0.0	
5	Баглагч машин	2005	ш	1	8,582,400.00	14,304,000.00	11,175,000.00	3,129,000.00	
6	Нэр бичих машин	2006	ш	1	30,914,400.00	51,524,000.00	33,812,630.00	17,711,370.00	
7	Тариур угсрах машин	2006	ш	1	50,235,900.00	83,726,500.00	54,945,520.00	28,780,980.00	
8	Компрессорын агаар хатаагч	2006	ком	1	12,008,700.00	20,014,500.00	13,134,520.00	6,879,980.00	
9	Компрессор	2006	ком	1	20,742,300.00	34,570,500.00	22,686,890.00	11,883,610.00	
10	Цутгуурын машин-100	2007	ш	1	101,333,061.30	168,888,435.01	135,110,748.01	33,777,687.00	
11	Цутгуурын машин-170	2007	ш	1	110,021,697.30	183,369,495.07	146,695,596.06	36,673,899.01	
	Нийт дүн				388,688,048.60	945,561,680.08	806,725,154.06	138,836,526.02	150,000,000.00
					(гурван зуун наян найман сая зургаан зуун наян найман дөчин найман төгрөг жаран мөнгө)	(есөн зуун дөчин таван сая таван зуун жаран нэгэн мянга зургаан зуун наян төгрөг найман мөнгө)	(найман зуун зургаан сая долоон зуун хорин таван мянга нэг зуун тавин дөрвөн төгрөг зургаан мөнгө)	(нэг зуун гучин найман сая найман зуун гучин зургаан мянга таван зуун хорин зургаан төгрөг хоёр мөнгө)	(нэг зуун тавин сая)